



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/460

Булган сум

Ой тэмдэглэж байгаа сум, байгууллагуудад  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны VII/46, VII/43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Баян-Агт сум байгуулагдсаны 100 жилд 10,000,000 (арван сая) төгрөг, Хялганат тосгоны 50 жилд 10,000,000 (арван сая) төгрөг, Булган сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 100 жилд 10,000,000 (арван сая) төгрөг, Бүрэгхангай сумын сургуулийн 100 жилд 10,000,000 (арван сая) төгрөг, Хутаг-Өндөр сумын сургуулийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд 10,000,000 (арван сая) төгрөг, Орхон сумын "Дөрвөн түмэн адууны баяр"-ыг зохион байгуулахад сумын Засаг даргын тамгын газарт 10,000,000 (арван сая) төгрөг, Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв үүссэн байгуулагдсаны 50 жилийн ойд 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

